



“Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг хөтлөх заавар

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6, 7, 8 дугаар зүйлд заасны дагуу соёлын өвийн улсын бүртгэл–мэдээллийн санг бүрдүүлэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 541 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг баримтлана.

1.2 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийг хөтлөхдөө Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”, түүх, соёлыг дурсгалыг бүртгэхтэй холбогдон гарсан бусад хууль, стандарт, эрх зүйн акт баримтад нийцүүлэн үнэн зөв бүртгэнэ.

1.3 “Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 2.2, 2.3-д заасны дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд /цаашид СӨУНБМС гэнэ/ ирүүлэх ба бүртгэлийн хувийг шат, шатны бүртгэл-мэдээллийн сан тус бүрд хадгална. Бүртгэл-мэдээллийн сангаас ирүүлсэн бүртгэлд ямар нэг засвар хийхийг хориглоно.

1.4 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийг гараар, хар өнгийн бэхтэй үзэг, бал хэрэглэн хөтөлж болно. Бүртгэл дэх асуулгын дагуу бичих мэдээлэл тухайн нүдэндээ багтахгүй бол А4 хэвлэлийн хуудсан дээр тухайн нүдний асуулгын нэрийг нэмэлт мэдээллийн хамт бичээд хавсаргана.

1.5 Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл нь Монгол Улсын соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдлийг бодит мэдээллээр хангах зорилготой бөгөөд шат, шатны бүртгэл-мэдээллийн сангийн тулгуур эх баримт болно

Хоёр. Бүртгэл хөтлөх

2.1 УБМС-ийн дугаар:

Энэ дугаарыг зөвхөн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангаас өгнө.

2.2 Аймаг, Нийслэл:

Сум, Дүүрэг:

Дурсгалт зүйлийн харьяалах Засаг захиргааны нэгжийн нэрийг бичнэ. Харин тэдгээрийн арын **БМС-ийн дугаар** гэсэн нүдэнд аймаг, нийслэл, сум, дүүргийн бүртгэл-мэдээллийн сангаас өгсөн дугаарыг бичнэ. БМС-ийн дугаарыг давхардуулан өгөхийг хориглоно.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг судлах, сурталчилах, сэргээн засварлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын бүртгэл-мэдээллийн сан энэхүү бүртгэлээр бүртгэл хийх бол Аймаг, нийслэл гэсэн нүдэнд өөрийн байгууллагын нэрийг гараар бичиж дугаарыг өгч болно.

2.3 Өмчлөгч:

Энэ нүдэнд “Монгол Улс” гэж бичнэ. Хэрэв бүртгэлд хамрагдаж байгаа дурсгалт зүйл хил дамнан оршиж байгаа бол эхлээд “Монгол Улс”, дараа нь тухайн дурсгалт зүйл хамаарах газар нутагт нь байгаа улсын нэрийг бичнэ.

2.4 Эзэмшигч:

Энэ нүдэнд тухайн дурсгалт зүйлийг албан байгууллага, иргэнд гэрээгээр эзэмшүүлж байгаа бол тухайн байгууллага болон хүний харьяалагдах засаг захиргааны нэр, өөрийн нэрийг

регистрийн дугаарын хамт тус тус бичнэ. Хэрэв хэн нэгэнд гэрээгээр ашиглуулаагүй бол зөвхөн тухайн орон нутгийн засаг захиргааны нэрийг бичнэ.

2.5 Дурсгалт зүйлийн нэр:

Энд тухайн дурсгалын нэрийг бичнэ. Ингэхдээ нийтэд нэршиж заншсан нэрийг бичих зарчмыг баримтлана. Хэрэв хэд хэдэн нэрээр нийтэд түгсэн бол шинжлэх ухааны эргэлтэд хамгийн түгээмэл нэрлэгдэж байгаа нэрийг нь бичээд хаалтанд бусад нэрийг нь бичиж болно.

Шинээр дурсгалыг нэрлэж бичих бол дурсгалт зүйлийн хамаатах хамгийн ойрын газрын нэрийг ашиглана.

2.6 Дурсгалт зүйлийн ангилал:

Энд тухайн бүртгэлд хамрагдаж буй дурсгалын ангилал аль нүдэнд хамаарахыг нь / + / тэмдгээр тэмдэглэнэ.

Бүртгэлд хамрагдаж байгаа дурсгалт зүйл дээрх төрлүүдэд хамаарагдахгүй бол энэ нүдэнд тэмдэглэгээ хийлгүй үлдээж болно. Хэрэв өөр өөр дурсгал цогцолбор байдлаар нэг дурсгалын нэрийн дор хамрагдаж байгаа бол төрөл тус бүрийн дор / + / тэмдэглэгээ хийнэ.

2.7 Оршин буй Засаг захиргааны нэгжийн нэр:

Дурсгалт зүйлийн оршин буй засаг захиргааны нэгжийн нэрийг аймаг-сум-баг, нийслэл-дүүрэг-хороо гэсэн дарааллын дагуу бичнэ. Хэрэв тухайн дурсгал 2 ба түүнээс дээш Засаг захиргааны нэгжид харъяалагддаг бол шинжлэх ухааны эргэлтэд орсон Засаг захиргааны нэгжийн нэрийг эхэнд нь бичээд дараа нь бусад Засаг захиргааны нэгжийн нэрийг бичнэ.

2.8 Орон зайн байршил:

Бүртгэлд хамрагдаж байгаа дурсгалт зүйл Засаг захиргааны нэгжээс аль зүгт, хэдэн км-ийн зайд оршиж байгааг тоогоор бичнэ. Хэрэв тухайн дурсгал хэд хэдэн Засаг захиргааны нэгжид хамрагддаг бол **Оршин буй засаг захиргааны нэгжийн нэр** гэсэн хэсэгт түрүүлж бичигдсэн засаг захиргааны нэгжийн нэрийг баримтлан бичнэ. Орон зайн байршилын хэмжээг “гаруй”, “орчим”, “-аад⁴”, гэх мэт тойм тоогоор илэрхийлж болно.

2.9 Газар зүйн байршил:

Дурсгалт зүйлийн оршин буй газар зүйн солбицлыг GPS багажийн тусламжтайгаар тогтоон дүйцэх нүдэнд тоогоор бичнэ.

2.10 Холбогдох он цаг:

Дурсгалт зүйлийн холбогдох он цагийг тоогоор бичнэ. Хэрэв тухайн дурсгалын он цагийг соёлын хүрээнд хамаатуулахаар бол холбогдох он цагийг хаалтан дотор тоогоор бичнэ. Жишээлбэл /Төмрийн түрүү үе (НТӨ /Нийтийн тооллын өмнөх/ YII-III зуун) г.м./

Тухайн дурсгалт газар олон үед холбогдох дурсгалаас бүрдэл болж буй бол он цагийн дарааллыг баримтлан дурсгал тус бүрийн холбогдох он цагийг бичнэ.

2.11 Эрх зүйн хамгаалалтын байдал:

Бүртгэлд хамрагдаж буй дурсгалын эрх зүйн хамгаалалтын байдлыг тохирох нүдэнд / + / тэмдгээр тэмдэглэнэ. Хэрэв тухайн дурсгал хэд хэдэн эрх зүйн актаар хамгаалагдсан байвал хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хамгаалалтын актыг баримтлан тэмдэглэгээ хийнэ.

Улсын хамгаалалтад, аймаг, нийслэлийн хамгаалалтад давхар байгаа бол энэ хоёр нүдэнд хоёуланд нь / + / тэмдгээр тэмдэглэгээ хийнэ.

Хамгаалалтанд авсан шийдвэр: Энэ хэсэгт тухайн дурсгалтай холбоотой эрх зүйн хамгаалалтын бүх актуудыг он дарааллын дагуу бичиж тэмдэглэнэ.

2.12 Дурсгалт зүйлийн бүрдэл:

Тухайн дурсгалт газрын хүрээнд хамрагдаж байгаа бүх дурсгалт зүйлийг тоо ширхэгээр нь бичиж тэмдэглэнэ. Жишээлбэл Тонюкукийн дурсгалыг энэхүү нүдний асуулгын дагуу бүртгэхдээ: “гэрэлт хөшөө 2 ш, тахилын хайрцагны чулуун хавтан 4 ш, чулуун хонь 3 ш, дүрслэлгүй хөшөө 1 ш, хүн чулуун хөшөө 2 ш, балбал /зэл/ чулуу 826 ш” гэх мэтээр тоочин бичнэ.

2.13 Дурсгалт зүйлийн анх нээж илрүүлсэн:

Тухайн дурсгалыг анх олж илрүүлсэн хувь хүн, судалгаа эрдэм шинжилгээний ангийн нэр, огноог бичнэ.

2.14 Хэмжээ:

Бүртгэлд хамрагдаж буй дурсгалын хэмжээсийг авч дүйцэх нүдэнд тоогоор бичих ба тухайн дурсгалын эзлэх талбайн хэмжээг заавал бичнэ. Мөн дурсгалын нэрийн дор цогцолбор байдлаар оршиж байгаа дурсгалуудын хэмжээсийг нэг бүрчлэн авч **Бусад хэмжээс:** нүдэнд дээрээс доош дугаарлан дээрх нүдэнд бичигдсэн 5 хэмжээсийн дарааллыг баримтлан бичнэ.

2.15 Хадгалалт хамгаалалтын байдал:

Тухайн дурсгалын бүртгэлд хамрагдаж буй цаг үед ямар байдалтай хадгалагдаж, ашиглагдаж байгаа талаар болон тухайн дурсгалын оршин буй байгаль орчны байдал, газрын тогтоц, хөрсний давхрага, цаг агаарын тухай мэдээлэл зэргийг бичнэ. Түүнчлэн дурсгалт зүйлийн эвдрэл гэмтлийн талаар тодорхой бичвэл зохино.

2.16 Тодорхойлолт:

Бүртгэлд хамрагдаж буй дурсгалын дүрслэгдэхүүн, хэлбэр, өнгө төрх, хийц маяг, бүтээсэн материалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ.

2.17 Товч түүх:

Дурсгалтай холбоотой түүхэн баримт, аман яриа, домог, зан үйлийн талаарх мэдээллийг бичнэ.

2.18 Судлагдсан байдал:

Тухайн дурсгал судалгаа эрдэм шинжилгээний эргэлтэнд орсон талаарх мэдээллийг тоймлон бичнэ. Мөн дурсгалын талаар гарсан ном бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, сонин сэтгүүлийн нийтлэл зэргийн зохиогч, нэр, хэвлэгдсэн оны хамт тоочин бичнэ.

2.19 Сэргээн засварласан байдал:

Бүртгэлд хамрагдаж байгаа дурсгалын сэргээн засварлагдсан байдлыг хэзээ, хэн, ямар хугацаагаар, аль хэсгийг, хэрхэн засварласан тухай мэдээллийг бичнэ.

2.20 Хавсралт материалын тэмдэглэл:

Бүртгэлд хавсаргах бусад мэдээлэл хэсэгт дурсгалтай холбоотой хувь хүний гар бичмэл, гар зураг, хувь хүнээс ирүүлсэн материалын тухай бичиж болно. Мөн дурсгалт зүйлийг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой мэдээллийг он дарааллын дагуу дэлгэрэнгүй бичнэ.

2.21 Бүртгэсэн:

Тухайн дурсгалыг бүртгэсэн хүн өөрийн нэр, ажлын газар, албан тушаалыг мөрний дээрх асуулгын дараалал дагуу бичнэ.

2.22 Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа гэрэл зураг, негатив хальс, дуу дүрс бичлэгийг хуурцаг, CD/DVD/BD, архив ном, хэвлэлийн баримт, бусад:

Бүртгэлийг бүрдүүлж байгаа бүртгэл-мэдээллийн сан нь нэрийнхээ доогуураа зурж тодотгоно. Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан нь түүх, соёлын дурсгалт зүйлийн холбогдолтой гэрэл зураг, негатив хальс, дуу дүрс бичлэгийн хуурцаг, CD/DVD/BD, архив, ном, хэвлэлийн баримт, судалгааны ажил, тайлан, холбогдох бусад материалаа хавтаслан, хадгаламжийн нэгж үүсгэн хадгална.

Тухайн дурсгалын холбогдох материал уг хадгаламжид ямар дугаартай байгааг бүртгэлийн “**хадгаламжийн дугаар**” нүдэнд, энэ нь хэдэн ширхэг, хэдэн хуудастай болохыг “**тоо ширхэг**” нүдэнд тус тус бичнэ.

2.23 Бүрдүүлэлт хийсэн:

Энд бүрдүүлэлт хийсэн хүн өөрийн нэр, ажлын газар, албан тушаалыг мөрний дээрх асуулгын дараалал дагуу бичнэ.